



Эргэн дурсах хүмүүс

ХИЛИЙН ДЭЭС АЛХААД ЭРГЭЖ ИРЭЭГҮЙ НЭГЭН

(Дурсамж тэмдэглэл)

Амьдралын хүнд нугачаанд алдраагүй

Алдар нэр горьдоогүй

Алдаж оносон ч гунихараагүй

Аюул сөрж тэмцэж явсан тэр л хүмүүсийг мартах учиргүйсэн.

XX зууны эхэн үеийн Монголын шашин төрийн зүтгэлтэн Дилав хутагт Жамсранжав, "1930 онд Эрэгдэндагва нарын хэрэгт холбогдож шүүхийн хурлаар шийтгүүлэх үед нь Намсрай хэмээх төлөөлөгч байсан тухай" дурдатгалдаа өгүүлсэн байдаг. "Намсрай маш чадвартай төлөөлөгч байсан бөгөөд надад ихээхэн тус болсон" гэж Дилав хутагт дурсжээ. Хожим Намсрай нь япончуудтай далдуур харилцаа тогтоосон бүлгийнхэнтэй холбоо бүхий этгээд гэж сэжиглэгдэх болсон тул 1937 оны хавар Ар монголоос дүрвэн гарч, 1939 онд Өвөр монголд Дилав хутагттай уулзаж хэсэг хугацаанд хамт байжээ.

Дилав хутагтыг япончуудаас зугатаж Чунцан хот ороход Намсрай Өвөрмонголд үлдсэн байна. "Япончууд Намсрайг Ар монголын нууц тагнуул байсан гээд 1944 онд цаазалжээ" хэмээн Дилав хутагт бичсэн байна. Намсрайг мэдэх хүн одоо байдаг болов уу? үгүй болов уу? гэдгийг сонирхон судалж байсан баримтаас иш татваас улаан эрдэмтэн гэж алдаршсан Бархасын Банзрагч агсан дурсахдаа "Намсрайтай хамт намын анхдугаар сургуулийг 1925 онд төгсөж билээ. Түүний тухай материал, хуучин Дотоод Яам, хотын шүүхийн архивт байж магадгүй" хэмээгээд цааш нь "...Намсрай авьяас чадвартай, шулуун шударга зантай сайн сурдаг, ялангуяа улс төрийн мэдлэг сайтай, олон нийтийн ажилд идэвхитэй оролцдогийг санаж байна" гээд Намсрайн гэргий байсан Гаанжуурын Мандах гуайн гэрийн хаягийг тодруулжээ.

Түмэнгийн Намсрай 1906 онд одоогийн Дорнод аймгийн Булган сумын нутагт малчин ардын гэр бүлд төржээ. 1925 онд Намын Төв сургуулийг төгсөөд цэрэгт явж, дараа нь хууль цаазын зургаан сарын түр сургуульд суралцаж улмаар Дорнод, Өмнөговь аймгийн шүүхийн дарга, 1932 оноос Улаанбаатар хотын шүүхийн даргаар ажиллажээ. Намсрайг 1932 онд Өмнөговь аймагт байхад нь зүүний

нугалаатан болгож намаас гаргасан байна.

Түүний гэргий байсан Мандах гуай: "Би хууль цаазны зургаан сарын курст суралцаж байхдаа Намсрайтай танилцаж 1930 онд гэр бүл болсон юм. Хэдэн жил амар жимэр амьдарч байтал 1935 онд Намсрай гэнэт салах тухай яриа үүсгэв. "Би чамд үнэхээр хайртай. Гэвч бид хоёр салах тавилантай" гэв Би цочин гайхаж: "Хайртай гэсэн мөртлөө сална гэдэг чинь юу гэсэн үг вэ? " гэхэд "Чамд хайртай болоод л хэлж байна. Учрыг нь ойлгох цаг хожим ирнэ ээ" гэж байсан. Ингээд бид хоёр салсан юм даа.

Намсрай миний эцэг Гаанжууртай ёс гүйцэтгэхээр 1937 оны дөрөвдүгээр сарын дундуур манайд ирэхдээ дэгжин хувцастай, алтан бөгж, хэт хутга зүүсэн байсан. "Би нутаг руугаа явлаа. Мөд ирэхгүй. Чи ажлаа сайн хийгээрэй" гээд мөрдсонсон. Дайны дараа л түүний тухай хэл чимээ дуулдав. Хамт үүрэг гүйцэтгэж явсан үнэнч нөхөд нь "тэр амьд яваа, ар гэр хамт олноо дурсаж, халуун эх орноо санагалзан, ирсэн өдөр байхад, буцах цаг ирнээ" хэмээн хүүрнэж байсан гэсэн. 1930-1940-өөд он . . . ээдрээтэй бөгөөд түгшүүртэй цаг байлаа. Манай улсын тусгаар тогтнолд бодитой аюул учраад байсан хүнд хэцүү үед ардын засгаас улс орныхоо аюулгүй байдлыг хангахын тулд хамаг хүчээ дайчилж төрөл бүрийн арга хэмжээ авсны дотор шилдэг хөвгүүдээ дайсны ар талд явуулж цагийн байдлыг туршуулахаар сөрөх хүчин болж байсны нэг нь Түмэнгийн Намсрай ажээ.

Ийнхүү далд фронтын дайчид дархан хилийн харуулчид хамтран хилийг дотор, гадна талаас нь харилцан хамгаалж, хаагуур нь гарах, хаанаас ирэхдээ дохио тэмдгээр мэдээлж элдэв дүр, төрх эсгэж хувилж байсан түүхэн баримт олон бий. . . . Алхаад марш тушаалаар, сэтгэлээ хувиргаагүй, зүсээ хувилгаж харьд очиж тусгай үүрэг гүйцэтгэсэн халуун эх орончид хилийнхээ дээсийг хэдэн удаа давж, хэд нь ирж, хэд нь ирээгүйг хэн эс мэдлээ. Харьж ирээгүй хайран хүмүүс хамгаалах газрын архивт л нэр нь мөнхөрдөг буй заа. Эх орон, эгэл түмнийхээ даалгаврыг биелүүлэхийн тулд эх нутаг, элгэн садан, анд нөхдөө орхин хүний нутагт очиж аюул сөрөн алтан амиа хайрлаагүй тэмцэж явсан, одоо амьд сэрүүн байгаа эрэлхэг дайчид, дайсны гарт амь эрсэдсэн зоригт хөвгүүдийнхээ нэр алдрыг сэргээхэд ардчиллын салхиар амьсгалах хэрэгтэй бус уу?

Харуул зангиас арай өөр бодолтой хар, цагааны дэнс болсон төлөөлөгч хүний тухай санаж, боддогоо "Төлөөлөгч бүхэн бууны нохой биш" гэсэн дараагийн тэмдэглэлд бичихийг хичээмөй.

Д.Бат-Юндэн